



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2016 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 01

Сүхбаатар

“Ил тод байдлыг хангах,
ажлын хариуцлагыг дээшлүүлэх жил”
болгон зарлах тухай

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.4.3 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төр, төсвийн байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн ил тод байдлыг ханган, төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлж, төрийн үйлчилгээг хүртэгч иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, зорилгоор 2016 оныг аймгийн хэмжээнд “Ил тод байдлыг хангах, ажлын хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарласугай.

2. Зарласан жилийн хүрээнд төрийн үйлчилгээний ил тод, нээлтэй байдлыг хангах төрийн албан хаагчийн ажлын хариуцлагыг дээшлүүлж, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллага, ажил албаныхаа онцлог нөхцөл, байдалд тулгуурлан бодлого зорилт дэвшүүлж, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг төр, төсвийн байгууллагын төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

3. Жилийн ажлын төлөвлөгөөний биелэлтийн явцын болон үр дүнд хяналт шинжилгээ хийж, үр дүнг тооцож ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА